



SARS-CoV-2-ын халдварыг илрүүлэх Фермент холбоот эсрэг биеийн урвалын (ФХЭБУ) оношлуур



ХОЛБОО БАРИХ

ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн байр,
Энхтайваны өргөн чөлөө 546, 14-р
хороолол, 13-р хороо, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар 13330, Монгол улс
Утас: 451781
e-мейл: biology@mas.ac.mn


ОНОШЛУУРЫН ТУХАЙ

Бидний боловсруулсан энэхүү оношлуур нь SARS-CoV-2 вирусийн нуклеокапсид (N) уурагт суурилсан, SARS-CoV-2 вирусийн эсрэг эсрэгбие үүссэн эсэхийг тодорхойлох, дархлаа тогтцыг хянах зорилгоор хэрэглэх боломжтой.

ОНОШЛУУРЫН ЗОРИУЛАЛТ

Энэхүү фермент холбоот эсрэг биеийн урвалаар EDTA, гепарин, нимбэгний хүчил бүхий сийвэн эсвэл ийлдсэнд SARS-CoV-2-ийн эсрэг эсрэгбиеийг илрүүлэхэд зориулагдсан. Зөвхөн мэргэжлийн, лабораторийн оношилгоонд хэрэглэнэ.

SARS-CoV-2 ВИРУСИЙН ФХЭБУ-ЫН ОНОШЛУУРЫГ АШИГЛАХ ДАРААЛАЛ



ОНОШЛУУРЫГ ГАРГАЖ АВСАН ҮЙЛ ЯВЦ

- 1 SARS-CoV-2 вирусийн геномын РНХ молекулыг ялган авч урвуу транскриптаза ашиглан кДНХ хуулах
- 2 Нуклеокапсид үүсгэгч N генийн тодорхой хэсгийг молекул биологийн аргаар олшруулан авах
- 3 Олшруулан ялган авсан N генийн хэсгийг генийн инженерчлэлийн арга ашиглан плазмидад угсрах
- 4 N уургийг нийлэгжүүлэх зорилгоор рекомбинант плазмидыг BL21 эсэд трансформаци хийх
- 5 Бактерийн эсэд нийлэгжсэн N уургийг биохими, иммунологийн аргаар цэвэршүүлэн ялган авч 96 нүхт хавтанд бэхлэх

ОНОШЛУУРЫН МЭДРЭГ БОЛОН ӨВӨРМӨЦ ЧАНАР ТОДОРХОЙЛСОН ҮР ДҮН

	Эерэг	Сөрөг
Эерэг	188	7
Сөрөг	12	69
Мэдрэг чанар	94%	
Өвөрмөц чанар	91.6%	

Оношлуурын мэдрэг, өвөрмөц чанарыг SARS-CoV-2 вирусийн халдварт өртсөн 200 эерэг дээж болон уг вирусийн халдвар тархахаас өмнөх 76 дээжийг ашиглан тодорхойлов.

ОНОШЛУУРЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

1. Бичил үүрт хавтан	1ш
2. 10х концентрацитай угаагч уусмал	50мл х 1ш
3. Хоёрдогч эсрэг бие	10мл х 1ш
4. ТМВ субстрат	5мл х 2ш
5. Зогсоогч	10мл х 1ш
6. Эерэг хяналт	2мл х 1ш
7. Сөрөг хяналт	2мл х 1ш
8. Дээж шингэлэх буфер	10мл х 1ш

